



# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНД ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХАНДАХ НЬ

Төв аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ,  
үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга  
Ч.Жавзанпагма



1. ОРШИЛ

2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

3. ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ

4. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТ

5. ДҮГНЭЛТ





# ОРШИЛ

---

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь:

Удирдлагын тогтолцоонд үр дүн, үр дагаварын талаар мэдээлэл өгч байх.

ХШҮ-ний тогтолцоо нь шийдвэр гаргагчдад төрийн захиргааны нэмэлт арга хэрэгсэл болно.



# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

## Хяналт- шинжилгээ, үнэлгээний систем

- байгууллагын бүтэц, удирдлагын үйл явц, стандарт, стратеги, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, мэдээллийн систем, тайлагнах тогтолцоо, хариуцлагын уялдаа холбоо зэргийн цогц бүрдэл



# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

## Хяналт- шинжилгээ

- нэг хэвийн, тасралтгүй бөгөөд гол шалгуур үзүүлэлтүүдийг ажиглах дотоод үйл ажиллагаа юм.

## Үнэлгээ

- тодорхой хугацаагаар хийх ба цаг хугацааны хязгаартай, тухайн үйл явцын шалтгаан, үр дагаварыг сайтар тодорхойлдог.




# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хяналт-шинжилгээ	Үнэлгээ
Тогтмол хийгдэж, үргэлжилж байдаг.	Үе үе хийгддэг, цаг хугацааны хязгаартай.
Дотоод үйл ажиллагаа	Дотоод, хөндлөнгийн эсвэл хамтын оролцоот үйл ажиллагаа
Удирдлагын хариуцах чиг үүрэг	Үнэлгээчид, ажилтнууд ба удирдлагатай хамт хүлээх хариуцлага
Хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахын тулд эргэх мэдээллийн холбоо тогтмол хийгддэг	Тодорхой хугацаанд эргэх мэдээллийн холбоо хийгдэнэ



# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ






# ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Алхам 1.	Асуудлыг тодорхойлох
Алхам 2.	Хүрэх зорилго, үр дүнгээ тодорхойлох
Алхам 3.	Шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг тодорхойлох
Алхам 4.	Судалгаа хийх
Алхам 5.	Хувилбаруудыг боловсруулан, дүн шинжилгээ хийх
Алхам 6.	Зөвлөмж боловсруулах
Алхам 7.	Бодлогыг сурталчлах
Алхам 8.	Дүн шинжилгээний чанарыг үнэлэх





# ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ





# ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖ



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ  
БАЙДАЛ



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ  
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХШҮ



# ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

## ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ

5.1.4. жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим: хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох;

19 дүгээр зүйл. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг

19.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1. тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүй нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

# ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



Жендэрийн  
хяналт,  
үнэлгээ

- улсын хэмжээний засаглалын тогтолцооны бүрэлдэхүүн

Жендэрийн  
үр  
нөлөөний  
үнэлгээ

- бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай нөлөөлж байгааг судлан шинжилж, сөрөг нөлөөг нь арилгах арга замыг тодорхойлох хэрэгсэл



# ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

## Жендэрийн мэдрэмжтэй хяналт, үнэлгээний систем

Жендэрийн  
хамааралтай үр  
нөлөөний үнэлгээг  
шийдвэр гаргах  
байнгын үйл  
ажиллагаанд  
нэвтрүүлэх

Жендэрийн үр  
нөлөөний үнэлгээний  
гүйцэтгэлийн  
шалгуур  
үзүүлэлтүүдийг  
боловсруулах,  
гүйцэтгэлийг хэмжих

Жендэрийн үр  
нөлөөний үнэлгээний  
тайлан бичих,  
танилцуулах



# ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ТУХАЙ ХУУЛЬ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

**ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ  
БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ,  
ТАВИГДАХ ШААРДЛАГА, САНХҮҮЖИЛТ**

**17 дугаар зүйл. Хөгжлийн бодлогын  
баримт бичиг боловсруулах үе шат,  
тавигдах шаардлага**

17.1.4. хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.

Засгийн газрын 2016 ны 249 дүгээр тогтоол

**“ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ  
НИЙТЛЭГ ЖУРАМ”**

9.9. “шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлтийг;

9.10. “суурь түвшин” гэж төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

9.11. “зорилтот түвшин” гэж бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг; гэж нарийвчлан заасан байна. Иймд бид бодлогын баримт бичиг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, суурь түвшинг зайлшгүй боловсруулах шаардлагатай



# ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

## Шалгуур ҮЗҮҮЛЭЛТ

- тухайн үйл ажиллагааны зорилго, зорилт, гүйцэтгэлтэй холбоотой зорилтот түвшинг тэдгээрийн ахицтай зэрэгцүүлэн хэмжихээр сонгож авсан хэмжүүр



# ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

<b>ОРЦ</b> <i>/input/</i>	<b>Санхүү, хүний нөөц, хангамжийн зүйлс</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> <i>/activity/</i>	Бүх төрлийн сургалт, зөвлөгөө, зөвлөмж, гарын авлага материал, үйлчилгээ, бэлтгэл болон үйл ажиллагааны явц
<b>ГАРЦ</b> <i>/output/</i>	Барьсан барилга байгууламж, техник технологийн шинэчлэл, аливаа үйл ажиллагаанд хамрагдагсдын тоо
<b>ҮР ДАГАВАР</b> <i>/outcome/</i>	Сайжирсан ажлын хандлага, эерэг өөрчлөлтүүд
<b>ҮР НӨЛӨӨ</b> <i>/impact/</i>	Урт хугацааны туршид нэмэгдэж буй иргэдийн үнэлэмж





# ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

## Шалгуур үзүүлэлтүүдийн ангилал

## Жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтүүдийн жишээ

### 1. Орцын шалгуур үзүүлэлт

Орцын шалгуур үзүүлэлтүүд нь хуваарилах гэж байгаа нөөцийн тоо хэмжээ болон түүнийг зарцуулах цаг хугацааг заадаг.

- Олон нийтэд түшиглэсэн малчдын бүлгийг дэмжих үйл ажиллагаанд эрэгтэй ба эмэгтэй өрхийн тэргүүнтэй айлуудаас оруулж байгаа санхүүгийн хувь хэмжээгээр

### 2. Явц дундын шалгуур үзүүлэлт

Хэрэгжилтийн явцад юу болж байгааг энэ шалгуур үзүүлэлтээр хэмждэг. Үйл явцын шалгуур үзүүлэлт нь тухайн төсөл хөтөлбөр юу хийхийг зорьсон тэдгээрт хамаардаг. Ихэнхдээ үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс бодит ажил хэрэг болсон үр дүнгүүдийн цогцоос эдгээр шалгуур үзүүлэлтийг авдаг.

- Зорилтот аймаг, сум, баг, дүүрэгт жендэрийн дүн шинжилгээ хийсэн байдлаар  
-Эмэгтэйчүүдийн өмч эзэмших ба зээлэнд хамрагдах эрхийн төлөө нөлөөллийн кампанит ажил эхлүүлсэн байдлаар  
- Тодорхой чиглэлээр МСҮТ-д сурч байгаа эрэгтэй, эмэгтэй оюутнуудын тоогоор

### 3. Гарцын шалгуур үзүүлэлт

Гарцын шалгуур үзүүлэлт нь төслийн санхүүгийн болон материалын гарцыг хэмждэг: материалын хэмжээ, байгууллагын чадавх, эхний ээлжийн үйлчилгээний урсгал гэх мэт.

- Барилгын материалын салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлтөөр  
- Боловсролын чиглэлээр сургууль төгсөөд мэргэжлээрээ ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн тооны өсөлтөөр



# ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

## 4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Төслийн завсрын буюу дунд хугацааны өөрчлөлтийг хэмждэг. Төслөөс тэтгэлэг авагчдад үзүүлж байгаа шууд үр нөлөөнд түлхүү анхаарал хандуулдаг бөгөөд төслийн үр нөлөө нь анх төлөвлөснөөс өөр болж байгаа эсэхийг хамаардаг.

- Эрэгтэй ажилчидтай харьцуулахад шинэ технологи ашиглаж эхэлсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувийн өсөлтөөр
- Бага ангиас дунд шатны боловсрол эзэмшихээр үргэлжлүүлэн суралцаж байгаа сурагчдын хувь, хүйсээр
- Уул уурхайн салбарт ажилд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувийн өсөлтөөр
- Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрчүүдийн дундах халдварт бус өвчний тархалтын хувийн бууралтаар

## 5. Үр нөлөөний шалгуур үзүүлэлт

Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь дунд хугацааны өөрчлөлтүүдийн үр дүнд илүү сайжирсан урт хугацааны ерөнхий өөрчлөлтийг хэмждэг.

- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундах ядуурлын түвшингийн бууралтаар
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зам тээврийн осол аваараас үүдэлтэй нас баралтын тооны бууралтаар
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дунд амьжиргааны түвшин сайжирсан байдлаар



# ДУГНЭЛТ

---

- Шийдвэр гаргах үйл ажиллагаанд жендерийн хамааралтай үр нөлөөний үнэлгээ хийх.
- Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төлөвлөсөн бодлого, хөтөлбөр маань хүссэн үр дүн, үр нөлөөг бий болгож байгаа эсэхийг харуулахын тулд жендерийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтүүд боловсруулах.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг танилцуулахдаа жендерийн эрх тэгш байдлыг хангаж байгаа эсэх асуудлыг оруулах.



# АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## НОМ ЗҮЙ

1. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь: Сургагч багшид зориулсан гарын авлага. Улаанбаатар 2014.
2. Жо Золл Кусек; Рей С.Рист: Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам. Вашингтон 2010.
3. Засаглалын үнэлгээг төлөвлөхүй: арга зам, ашиг тус, өртөг зардал. Хэрэглэгчийн гарын авлага. Улаанбаатар 2010.
4. Кевин Браун; Саара Репучи: Төрийн захиргааны ажил гүйцэтгэлийг хэмжихүй. Хэрэглэгчийн гарын авлага. Осло 2010.
5. Линда Г.Морра Имас; Рей С.Рист: Үр дүнд хүрэх зам. Вашингтон 2011.
6. Мянганы Сорилтын Сангийн Жендэрийн нэгдсэн тайлан: Тэргүүн туршлага ба сургамжууд, Монголын Мянганы Сорилтын сан (Б. Цолмонгийн хамтарсан бүтээл), 2013
7. Хөгжлийн үр дүнгийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний гарын авлага. Удирдлагын Академи. Улаанбаатар 2012.
8. Швейцарийн Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны хүрээлэн Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа. Улаанбаатар 2013.

Цахим хуудас:

<http://www.1212.mn/>

<http://vip76.mn/content/12931>

<https://www.slideshare.net/ariuntulgabyambadorj/ss-27655329>

<https://www.legalinfo.mn/law/details/11484>

<https://www.legalinfo.mn/annex/details/7310?lawid=11962>

<https://www.legalinfo.mn/law/details/253>

<http://gender.gov.mn/backend/files/FlqGfcXwvrIBr9t.pdf>

